



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 418

Улаанбаатар хот

“Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Үнэт цаасны хорооны 2005 оны 30 дугаар тогтоолын 3, 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны брокер, дилерийн компанийн үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийг гаргах журам”, “Үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх компанийн үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийг дүгнэх журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй


4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т, олон нийтэд мэдээллэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.МАРАНТУЯА

001126



АНДЕРРАЙТЕР, ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫГ ТООЦОХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагааг Хорооноос тусгай зөвшөөрөл авсаны үндсэн дээр эрхлэж байгаа зохицуулалттай этгээдийн төлбөрийн чадварыг тодорхойлох, шалгуур үзүүлэлтийг Хорооноос тогтоож, түүний биелэлтэд хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.

1.2. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэж буй зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардлагатай хууль тогтоомжид заасан хөрөнгөтэй байна.

1.3. Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийг чадварыг тооцох, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журам болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны “Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн заавар” болон бусад эрх зүйн актыг баримтлана.

1.4. Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1 “Өөрийн хөрөнгө” гэж тухайн андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн нийт хөрөнгийн дүнгээс өр төлбөрийг хассан дүн буюу эздийн өмчийн дүнг;

1.4.2 “Өр төлбөр” гэж тайлант хугацааны богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн нийлбэр дүнг;

1.4.3 “Урт хугацаат хөрөнгө оруулалт” гэж хараат, хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтыг;

1.4.4 “Үйл ажиллагааны зардал” гэж андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн үндсэн үйл ажиллагааны явцад үүсч буй үр ашгийн бууралтыг.

ХОЁР. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварын байдлыг тодорхойлохдоо “Хөрөнгийн зохистой харьцаа” үзүүлэлтээр тооцно.

2.2. “Хөрөнгийн зохистой харьцаа”-г тооцохдоо өөрийн хөрөнгөөс эргэлтийн бус хөрөнгийг хассан үзүүлэлтийг урт хугацаат хөрөнгө оруулалт, нийт өр төлбөрийн дүн, элэгдлийн зардал ороогүй үйл ажиллагааны зардлын эрсдлээр жигнэсэн нийлбэрт хувааж тооцно.

$$\text{Хөрөнгийн Зохистой харьцаа} = \frac{(\text{Өөрийн хөрөнгө} - \text{Эргэлтийн бус хөрөнгө})}{\text{Урт хугацаат хөрөнгө оруулалт}(x)\% + \text{Нийт өр төлбөр } x (y)\% + (\text{Үйл ажиллагааны зардал-элэгдлийн зардал}) x (z)\%} \times 100\%$$

2.3 Эрсдэл жигнэх хувь буюу x, y, z итгэлцүүрийн хэмжээг зах зээлийн нөхцөл байдал, төрөөс баримталж буй бодлоготой уялдуулан Хорооноос тогтооно.

2.4 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт нь 100 буюу түүнээс их байна.

2.5 Хэрэв андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлт 100-ээс доош байвал тухайн зохицуулалттай этгээдийг төлбөр гүйцэтгэх чадвар алдагдсанд тооцно.

2.6 Андеррайтерийн компанийн хувьд дээрх үзүүлэлтээс гадна эргэлтийн хөрөнгийн хувийн жин гэсэн үзүүлэлтийг нэмж тооцно.

2.7 “Эргэлтийн хөрөнгийн хувийн жин”-г тооцохдоо нийт эргэлтийн хөрөнгийг балансын цэвэр дүн буюу нийт хөрөнгийн дүнд харьцуулж, хувиар илэрхийлэн тогтооно.

Эргэлтийн хөрөнгийн хувийн жин = (нийт эргэлтийн хөрөнгийн дүн) / (нийт хөрөнгийн дүн) x 100%

$$\text{ЭХХЖ} = (\text{ЭХ} / \text{НХ}) \times 100\%$$

2.8 Андеррайтерийн компанийн эргэлтийн хөрөнгийн хувийн жин нь 70 хувь буюу түүнээс дээш байна.

ГУРАВ. ХӨРӨНГӨ БА ЗӨВШӨӨРӨГДӨХГҮЙ ХӨРӨНГӨ

3.1 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн нь тухайн компанийн нийт хөрөнгийн дүнгээс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хассанаар тодорхойлогдоно.

3.2 Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хэмжээг тухайн хөрөнгийн дүнгээс энэхүү журмын 3.3-д заасан хувиар тооцож гаргана.

3.3 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг дараах аргачлалын дагуу тооцно. Үүнд:

3.4 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь улирал бүрийн санхүүгийн тайлан дээр үндэслэн энэхүү журмын 2.2, 2.7, 3.3-д заасан нөхцлөөр, журмын хавсралтад заасан маягтын дагуу өөрийн төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцно.

3.5 Төлбөрийн чадварын үзүүлэлтийг тооцсон баримт дээр тухайн зохицуулалттай этгээдийн гүйцэтгэх захирал, түүнийг орлож буй этгээд болон нягтлан бодогч гарын үсэг зурж, компанийн тамга дарж баталгаажуулан өөрийн гишүүнчлэл бүхий өөрийгөө зохицуулах байгууллагад улирал бүр хүргүүлнэ.

3.6 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн гишүүнчлэлтэй өөрийгөө зохицуулах байгууллага нь гишүүн компанийн санхүү, төлбөрийн чадварын байдалд байнгын хяналт тавих, тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах үүрэгтэй.

3.7 Тухайн андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь төлбөрийн чадваргүй болсонд тооцогдож болзошгүй, эсхүл төлбөрийн чадваргүй болсон бол энэ талаар тус компанийн гишүүн өөрийгөө зохицуулах байгууллагаас Хороонд ажлын 2 хоногт багтаан, албан бичгээр мэдэгдэх үүрэг хүлээнэ.

3.8 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компани нь холбогдох журамд заасны дагуу эхний хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхдээ төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайланг хавсарган ирүүлнэ.

3.9 Төлбөрийн чадварын үзүүлэлтийн тайланг Монгол Улсын үндэсний валют болох төгрөгөөр илэрхийлнэ.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1 Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцсон ажиллагаанд тухайн брокер, дилерийн компанийн гишүүнчлэлтэй өөрийгөө зохицуулах байгууллага болон Хорооны Хяналт шалгалтын газар хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл газар дээрх шалгалтыг хийнэ.

4.2 Төлбөрийн чадваргүй болсонд тооцогдож болзошгүй, эсхүл төлбөрийн чадваргүй болсон талаарх анх мэдэгдэл ирүүлсэн, эсхүл хяналт шалгалтын дүнд тогтоогдсон тохиолдолд Хорооноос дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.2.1 албан бичгээр анхааруулах;

4.2.2 хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийг шаардах.

4.3 Үнэт цаасны брокер, дилерийн компанийн хувьд Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хагас болон жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр дараалан хангаж ажиллаагүй тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

4.4 Андеррайтерийн компанийн хувьд Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн аль нэгийг жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлээр 2 жил дараалан хангаж ажиллаагүй тохиолдолд тухайн компанийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авна.

4.5 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Андеррайтер, үнэт цаасны брокер, дилерийн компанийн төлбөрийн чадварыг тооцох, хяналт тавих тухай журам”-ын 1 дүгээр хавсралт

“.....” ХХК-ИЙН 20.. ОНЫ ... ХАГАС ЖИЛИЙН/ЖИЛИЙН ЭЦСИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Көэфф.	Тооцсон дүн
1	Нийт хөрөнгө		
2	Өөрийн хөрөнгө		
3	Эргэлтийн бус хөрөнгө		
4	Урт хугацаат хөрөнгө оруулалт х (x)%	(x = 100)	
5	(Урт хугацаат өр төлбөр + богино хугацаат өр төлбөр) х(y)%	(y = 100)	
6	(Үйл ажиллагааны зардал-элэгдлийн зардал) х (z)%	(z = 100)	
7	Хөрөнгийн зохистой харьцаа / (2-3)/ (4+5+6)x100%≥100/		
8	Эргэлтийн хөрөнгө /андеррайтерийн компанийн хувьд/		
9	Эргэлтийн хөрөнгийн хөрөнгийн хувийн жин/8/1x100/≥70		

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал: _____ огноо _____
Нягтлан бодогч: _____ огноо _____

/тамга/ гарын үсэг/